

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

№ 23-02/01

Улаанбаатар хот

**Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх, нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх, Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.8, 62.1.10-62.1.11 дэх заалт, 38 дугаар зүйл, 87-93 дугаар зүйл, 53, 54 дүгээр зүйл, 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн тооллогын комиссын ..... дугаар тогтоол, “Глобал Монголия Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо 107,306 (нэг зуун долоон мянга гурван зуун зургаа) ширхэг болохыг дурдсугай.
2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 999,892,694 (есөн зуун ерэн есөн сая найман зуун ерэн хоёр мянга зургаан зуун ерэн дөрөв) ширхэгээр нэмэгдүүлж, зарласан хувьцааны тоог нийт 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэгт хүргэхээр шийдвэрлэсүгэй.
3. Нэмж зарласан энгийн 1,000,000 ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгон хаалттай хүрээнд арилжаалахаар нэмж гаргасугай.
4. Хувьцаа нэмж гаргасны дараа Компанийн зарласан хувьцааны тоо 1,000,000,000 ширхэг, гаргасан энгийн хувьцааны тоо 1,107,306 ширхэг, зарласан боловч гаргаагүй хувьцааны тоо 998,892,694 ширхэг болохыг дурьдсугай.
5. Нэмж гаргах хувьцааны хаалттай хүрээнд санал болгох зах зээлийн үнийт 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрөөр тасалбар болгосон хувьцааны сүүлийн 30 хоногийн жигнэсэн дундаж ханш болох 1,307 төгрөгөөс 9,9%-иар хямдруулсан үнэ болох 1,178 /нэг мянга нэг зуун далан найм/ төгрөгөөр тогтоосугай.
6. Компанийн зарласан хувьцааны хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотой ажлыг хариуцан зохион байгуулах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
7. Нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

8. Хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ким Ки Хюун)-д олгосугай.
9. Компанийн үйл ажиллагааны чиглэлээс “реклам сурталчилгаа, болон гадаад худалдаа”-г тус тус хасч, дараах үйл ажиллагааны чиглэлийг нэмсүгэй. Үүнд:
  1. Гоо сайхны бүтээгдэхүүний худалдаа
  2. Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл
  3. Худалдааны зуучлал;
  4. Онлайн дэлгүүр;
  5. Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа;
  6. Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;
  7. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр зөвлөгөө өгөх;
  8. Хоёрдогч түүхий эд боловсруулах;
  9. Сүлжмэл, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл;
  10. Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл;
  11. Бэлэн хувцас үйлдвэрлэл;
  12. Гэрээгээр өрөмдлөгөх хийх;
  13. Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх;
  14. Фермерийн аж ахуй;
  15. Програм хангамжийн үйл ажиллагаа;
  16. Компьютерын засвар үйлчилгээ, зөвлөгөө өгөх;
  17. Мэдээлэл технологийн үйл ажиллагаа;
  18. Вэб сайтын үйлчилгээ;
  19. Санхүүгийн тайлан баланс бэлтгэн гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх;
  20. Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
  21. Байгалийн ухааны эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил;
  22. Зах зээлийн болон социологийн судалгаа хийх;
  23. Сүлжмэл, нэхмэл эдлэл, гутлын худалдаа;
  24. Бэлэн хувцас худалдаа;
  25. Хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн түрээс;
  26. Аялал жуулчлал;
  27. Бизнесийн зөвлөгөө өгөх;
10. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлсэн, нэмж хувьцаа гаргасан, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн, компанийн үйл ажиллагааны

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

чиглэлийг өөрчилсөнтэй холбогдуулан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.

11. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хууль, журамд заасан хугацаанд хүргүүлэх, холбогдох зөвшөөрлийг авах, холбогдох зөвшөөрлийг авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг харицуан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ким Ки Хюунд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



ХАН ГЮ БУН

# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

№ 23-02/02

Улаанбаатар хот

## Шаардах эрх хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйл, “Глобал Монголия Холдингс” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдаж буйтай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанийд хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй болохыг дурьдсугай.
2. Нэмж хувьцаа гаргахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тус тус зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг нэг бурийг 1,178 төгрөгөөр худалдаж авахыг зөвшөөрсүгэй.
3. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж, Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
4. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.
5. Компани нэмж хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах Хороонд шаардлагатай бүртгэл хийгдсэний дараагаар Хувьцаа эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын дагуу, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Ким Ки Хюун)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захиралд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:

ХАН ГЮ БУН:



# “ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

№ 13-ХХ/03

Улаанбаатар хот

## Гаули УЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах эсэх тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн тооллогын комиссын ..... дугаар тогтоол, “Глобал Монголия Холдингс” ХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гаули УЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгон шийдвэрлүүлсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулж Гаули УЦК ХХК-ийн хувьцааг худалдан авах тухай асуудлыг хэлэлцэхийг даалгасугай.
1. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ким Ки Хюун/-д даалгасугай.

